



# МОНГОЛ УЛС

## ШАДАР САЙДЫН ТУШААЛ

20<sup>дүйн</sup> оны 26 дугаар  
сарын 06-ны өдөр

Дугаар 58

Улаанбаатар  
хот

Журам батлах тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 27<sup>1</sup> дүгээр зүйл 27<sup>1.1.1</sup>, 28 дугаар зүйлийн 28.1.5, Коронавируст халдварт /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.8, 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Коронавируст халдварт (Ковид-19)-ын цар тахлын үед хилийн боомтоор зорчигч, тээврийн хэрэгсэл, бараа, бүтээгдэхүүнийг нэвтрүүлэх журам”-ыг нэгдүгээр, “Олон улсын зорчигч, ачаа тээврийн нислэгийн үед хэрэгжүүлэх халдвараас сэргийлэх хариу арга хэмжээний заавар”-ыг хоёрдугаар, “Хилийн боомтод халдвараас сэргийлэх хариу арга хэмжээний үед ажилтан, албан хаагчдын хэрэглэх хувийн хамгаалах хувцас хэрэгслийн иж бүрдлийн жагсаалт”-ыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Журмын хэрэгжилтийг ханггуулж ажиллахыг Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (Т.Гантулга), Гаалийн ерөнхий газар (Б.Асралт), Хил хамгаалах ерөнхий газар (бригадын генерал Х.Лхагвасүрэн), Гадаадын иргэн, харьяатын газар (Н.Ууганбаяр)-т тус тус үүрэг болгосугай.

3. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Улсын онцгой комиссын орлогч дарга, Онцгой байдлын ерөнхий газрын дарга (хошууч генерал Г.Ариунбуян)-д даалгасугай.



Монгол Улсын Шадар сайд,  
Улсын онцгой комиссын дарга

С.АМАРСАЙХАН

Монгол Улсын Шадар сайдын 2021 оны  
... дугаар сарын ...-ны өдрийн... дугаар  
тушаалын нэгдүгээр хавсралт

КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19)-ЫН ЦАР ТАХЛЫН ҮЕД  
ХИЛИЙН БООМТООР ЗОРЧИГЧ, ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ,  
БАРАА, БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ НЭВТРҮҮЛЭХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Коронавируст халдварт (Ковид-19)-ын цар тахлын үед хилийн боомтоор зорчигч, тээврийн хэрэгсэл, бараа, бүтээгдэхүүнийг нэвтрүүлэхэд хяналт шалгалт хийх, боомтын бэлэн байдал, хариу арга хэмжээний нөхцөл байдлыг үнэлэх, хилийн хөдөлгөөнийг үе шаттайгаар нээх, хилийн хяналтын болон бусад байгууллагын үйл ажиллагааг уялдуулан зохион байгуулах, халдвартын сэжигтэй зорчигчийг илрүүлэх, тандах, тусгаарлалтад шилжүүлэх зэрэг авч хэрэгжүүлэх хариу арга хэмжээ, хорио цээр, халдварт хамгааллын дэглэмийг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Хилийн боомтоор нэвтрүүлэх зорчигч, тээврийн хэрэгсэл, бараа бүтээгдэхүүнд хяналт шалгалтыг хийхдээ Монгол Улсын Олон улсын гэрээ хэлэлцээр, Олон Улсын эрүүл мэндийн дүрэм (ОУЭМД-2005), Төрийн хяналт шалгалтын тухай, Гамшгаас хамгаалах тухай, Коронавируст халдварт /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай, Эрүүл мэндийн тухай, Эрүүл ахуйн тухай, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт шалгалтын тухай, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль, Улсын онцгой комисс, Засгийн газрын тогтоол, шийдвэр, Эрүүл мэндийн сайдын тушаал болон холбогдох дүрэм, журамд нийцүүлнэ.

1.3. Хилийн боомт, гаалийн хяналтын бүсийн “Гамшгаас хамгаалах бэлэн байдлын төлөвлөгөө”-нд коронавируст халдварт (Ковид-19)-аас сэргийлэх, хариу арга хэмжээ авах чиглэлээр тухай бүр тодотгол хийж, хэрэгжилтийг хангаж ажиллана.

1.4. Хилийн боомт дахь “Хилийн боомтын зөвлөл” нь коронавируст халдварт (Ковид-19)-аас сэргийлэх, хариу арга хэмжээний төлөвлөгөөг баталж, эрсдэлийн үнэлгээг хийж, чадавхыг сайжруулна.

1.5. Хилийн боомт, гаалийн хяналтын бүсэд халдвараас сэргийлэх, хариу арга хэмжээ авах үйл ажиллагааг мэргэжлийн хяналтын байгууллагын зөвлөмж, мэргэжил арга зүйн дагуу хэрэгжүүлнэ.

ХОЁР. НЭР, ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

2.1. “Тохиолдол” гэж тухайн өвчний батлагдсан болон сэжигтэй, магадлалтай тохиолдлыг;

2.2. “Халдварт” гэж халдварт өвчний үүсгэгч хүн, амьтны биед нэвтрэн орж, өсөж үржихийг;

2.3.“Тусгаарлах” гэж халдвар авсан байж болзошгүй сэжигтэй хүн, мал амьтан, халдвар үүсгэгчээр бохирлогдсон гар тээш, ачаа, чингэлэг, тээврийн хэрэгсэл, бараа, шуудангийн илгээмжийг халдвартгүй хэсгээс ялган тусгаарлах арга хэмжээг;

2.4.“Ажиглах” гэж халдвар дамжих аюулыг тодорхойлох зорилгоор тодорхой хугацааны туршид хүн, малын эрүүл мэндийг хянах үйл ажиллагааг;

2.5.“Халдварлагдсан” гэж хүн амын эрүүл мэндэд эрсдэл учруулах халдвар тээгч хүн, мал амьтан болон халдвараар нас барсан хүн, мал амьтны цогцос, халдвар үүсгэгчээр бохирдсон эд зүйл, тээврийн хэрэгсэл, барааг;

2.6.“Халдвартгүйжүүлэлт” гэж хүн, амьтан, тээврийн хэрэгсэл, барааны дотор болон гадна хэсэгт байгаа халдвар үүсгэгчийг физик болон химийн аргаар устгах, эсхүл тоог цөөрүүлж халдвар тархахгүй байх нөхцөлийг бий болгох арга хэмжээг;

2.7.“Сэжигтэй тохиолдол” гэж халуурах, ханиалгах, толгой, булчин, хоолой өвдөх, амьсгаадах, хоолны дуршил буурах, дотор муухайрах, бөөлжих, суулгах, ядарч сульдах, амт, үнэр мэдрэхгүй болох, сэтгэл санаа тогтвортгүй байх зэрэг эмнэлзүйн шинж тэмдгээс 3 болон түүнээс дээш илэрсэн, шинж тэмдэг илрэхээс 7-14 хүртэлх хоногийн өмнө коронавируст халдвар хүн амын дунд өргөн тархсан бус нутагт амьдарч байсан буюу аялсан, тусгаарлан ажиглах байранд тусгаарлагдсан, олныг хамарсан үйл ажиллагаанд оролцсон, эрүүл мэндийн байгууллагад ажиллаж байсан хүнийг;

2.8.“Магадлалтай тохиолдол” гэж энэ журмын 2.7-д заасан эмнэлзүйн шинж тэмдэг илэрсэн, коронавируст халдвар (КОВИД-19)-ын батлагдсан тохиолдолтой хавьтал болсон, тархвар судлалын хувьд батлагдсан тохиолдлын багц (кластер)-д хамаарах хүнийг;

2.9.“Батлагдсан тохиолдол” гэж эмнэлзүйн шинж тэмдэг илэрсэн эсэхээс үл хамааран лабораторийн шинжилгээгээр коронавируст халдвар (КОВИД-19)-тай болох нь тогтоогдсон хүнийг;

2.10.“Ойрын хавьтал” гэж сүүлийн 7-14 хоногийн хугацаанд коронавируст халдвар (КОВИД-19)-ын магадлалтай болон батлагдсан тохиолдолтой хамт галт тэрэгний нэг тасалгаа, вагон, автобус, суудлын болон ачааны автомашин, агаарын хөлөгт тухайн зорчигчийн урд, хойд, хажуугийн 3 эгнээнд суусан зорчигчид, үйлчилгээ үзүүлсэн ажилтанг;

2.11.“Халдвараас сэргийлэх хамгаалалтын бус” гэж хилийн боомт, гаалийн хяналтын бусээр нэвтэрч буй зорчигчдод эрүүл мэндийн хяналт тандалт хийх, тээврийн хэрэгсэл, барааг халдвараас сэргийлэх дэглэмийн дагуу нэвтрүүлэхээр зохион байгууллагдсан бүсийг хэлнэ.

2.11.1.Халдвараас сэргийлэх хамгаалалтын бус нь улаан, шар, ногоон гэсэн тусгай дэглэм бүхий бусээс бүрдэнэ.

- Халдварын эрсдэлтэй буюу “Улаан бус” /цаашид улаан бус гэх/ гэж зорчигчийн эрүүл мэндийн хяналт тандалт хийх, халдварын эрсдэл бүхий бус нутгаас ирсэн ачаа тээш, тээврийн хэрэгсэл, барааг улсын хилээр нэвтрүүлэхэд хяналт тавих, уг үйл ажиллагаанд оролцсон хилийн хяналтын байгууллагын албан хаагч, иргэн, хуулийн этгээдийг хувийн хамгаалах хувцастай нэвтрүүлэх, зориулалтын байгууламж, зам, талбайгаар

хязгаарлаж, халдвартай хог хаягдлыг устгах зориулалт бүхий тусгаарлагдсан бүсийг;

- Завсрын буюу "Шар бүс" /цаашид шар бүс гэх/ гэж улаан бүсээс халдвар дамжин тархах нөхцөлийг хязгаарлан, хөдөлгөөний хяналт зохицуулалтыг хийх, ажилтан, албан хаагчдын хувийн хамгаалах хувцас хэрэгслийг тайлах, халдвартай хог хаягдлыг устгах зориулалт бүхий тусгаарлагдсан бүсийг;

- Халдвартай буюу "Ногоон бүс" /цаашид ногоон бүс гэх/ гэж улаан, шар бүс рүү орохоос өмнө хувийн хамгаалах хувцсыг өмсөх нөхцөлийг бүрдүүлсэн, дээрх бүсүүдэд үйл ажиллагаа явуулахад хяналт тавих боломжоор хангагдсан, ашиглагдаж буй барилга байгууламж, өрөө тасалгаа зам талбай, гадаад, дотоод орчин нь халдварын эрсдэлгүй болох нь тогтоогдсон бүсийг хэлнэ.

2.12. Хилийн боомтын зөвлөл нь "Халдвараас сэргийлэх хамгаалалтын бүс"-ийг мэргэжлийн хяналтын байгууллагын саналыг үндэслэн хилийн боомтод тогтооно.

2.13. Гаалийн хяналтын бүсэд "Халдвараас сэргийлэх хамгаалалтын бүс"-ийг гаалийн байгууллага, хуулийн этгээдийн саналыг үндэслэн мэргэжлийн хяналтын байгууллагаас тогтооно.

#### **ГУРАВ."ХАЛДВАРААС СЭРГИЙЛЭХ ХАМГААЛАЛТЫН БҮС"-Д ТАВИГДАХ ШААРДЛАГА**

3.1. Халдварын голомтот бүс нутгаас ирсэн зорчигч, тээврийн хэрэгсэл, бараатай харьцах ажилтан, албан хаагчийн тоог аль болох цөөн байхаар тооцоолж, үйл ажиллагааг явуулна.

3.2 Халдварын сэжигтэй зорчигч, ажилтан, албан хаагч болон ойрын хавьтлыг түр тусгаарлах өрөө, эмнэлгийн зориулалттай зөөврийн хаалт болон хэсэгчлэн тусгаарлах талбайг төлөвлөсөн байна.

3.3. Бүсийн зааг тогтооход шаардлагатай туузан тусгаарлагч, тэмдэг тэмдэглэгээг монгол, англи болон хил залгаа улсын хэлээр бичиж байршуулна.

3.4. Зорчигч, тээврийн хэрэгслийн орох, гарах хөдөлгөөний урсгалыг тус тусад нь төлөвлөсөн байна.

3.5. Шуурхай мэдээ, мэдээлэл дамжуулах холбооны хэрэгсэл, хяналтын камер, үйл ажиллагаанд шаардлагатай бусад тоног төхөөрөмжөөр бүрэн хангасан байна.

3.6. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ шаардлагатай болон хөгжлийн бэрхшээлтэй зорчигчдод зориулсан тусгай хэрэгсэл /тэргэнцэр, дамнуурга г.м/-ийг урьдчилан бэлтгэсэн байна.

3.7. Аюултай хог хаягдлыг цуглуулах, түр хадгалах, тээвэрлэх, устгах цэгийг тогтоож, халдвараас сэргийлэх дэглэмийн дагуу битүүмжлэх, халдвартай хог хаягдлыг устгах зориулалт бүхий нөхцөлийг бүрдүүлнэ.

3.8. Хилийн хяналтын болон бусад байгууллагын албан хаагч, зорчигч, жолооч нь тухайн бүсэд халдвараас сэргийлэх дэглэмийг чанд мөрдөнө.

### 3.9. “Улаан бүс”-д тавигдах шаардлага

3.9.1. Бүсийн орох, гарах гарцыг тодорхойлсон тэмдэг, тэмдэглэгээтэй байна.

3.9.2. Халдварт өвчний сэжигтэй зорчигчийг түр тусгаарлах байр байрлаж, уг байранд тусгайлсан дэглэм мөрдөгдөнө. Түр тусгаарлах өрөөг шаардлагын дагуу тохижуулсан байна.

3.9.3. Тухайн бүсэд хилээр нэвтэрч буй ачаа, тээврийн хэрэгсэл, бие засах газрыг халдваргүйжүүлэх төхөөрөмж байрлана.

3.9.4. Улаан бүсэд зорчигчийн халууныг хэмжих суурин болон зөөврийн төхөөрөмжийг ашиглана.

3.9.5. Хилийн хяналтын болон бусад байгууллагын ажилтан, албан хаагч нь ажлын чиг үүргээс хамаарч энэхүү тушаалын гуравдугаар хавсралтаар батлагдсан “Хилийн боомтод халдвараас сэргийлэх хариу арга хэмжээний үед ажилтан албан хаагчдын хэрэглэх хувийн хамгаалах хувцас хэрэгслийн иж бүрдлийн жагсаалт”-д заасны дагуу хувийн хамгаалах хувцас, хэрэгсэлтэй ажиллана.

3.9.6. Зорчигчийн гар, эд зүйлс, бараа, тээврийн хэрэгслийг халдваргүйжүүлэх уусмал, багаж, тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдсан байна.

3.9.7. Зорчигч гар угаах, бие засах нөхцөлөөр хангагдаж, шаардлага хангасан ариун цэврийн өрөөгөөр үйлчлүүлнэ.

3.9.8. Хяналт шалгалтын тоног төхөөрөмж, техник хэрэгслийг бус дамжуулан ашиглах тохиолдолд дамжлага тус бүрт халдваргүйжүүлнэ.

3.9.9. Улаан бүсэд зорчигч, тээврийн хэрэгсэл, барааг хяналт шалгалтад оруулах, гаргах ажиллагааг хяналттай, нэгдсэн удирдлагатайгаар зохион байгуулна.

3.9.10. Сэжигтэй тохиолдлыг эрүүл мэндийн байгууллагад шуурхай шилжүүлэх унаагаар хангагдсан байна.

3.9.11. Эрүүл мэндийн шалтгаантай болон хөгжлийн бэрхшээлтэй зорчигчийг тээвэрлэх дамнуурга, тэргэнцрийг бэлтгэсэн байна.

### 3.10. “Шар бүс”-д тавигдах шаардлага

3.10.1. Бүсийн орох, гарах гарцыг тодорхойлсон тэмдэг, тэмдэглэгээтэй байна.

3.10.2. Авто замын боомтод хувийн хамгаалах хувцас, хэрэгслийг тайлах зөөврийн байртай /пункт/ байна. Уг пунктэд хувийн хамгаалах хувцас хэрэгсэл тайлах зааврыг байршуулсан байна.

3.10.3. Тухайн бүсэд бараа, бүтээгдэхүүнийг сэлгэн ачих дундын талбай байрлана.

3.10.4. Бүсэд нэвтрэх ажилтан, албан хаагчийн хөдөлгөөн нь бүртгэл, хяналттай байна.

3.10.5. Хувийн хамгаалах хувцас хэрэгсэл, толь, халдвартгүйтгэлийн бодис, ажлын уусмал бэлтгэх сав, аюултай хог хаягдал цуглуулах, хадгалах уут, сав /50-л ээс доошгүй хэмжээтэй/, бусад шаардлагатай багаж хэрэгслийг байрлуулна.

3.10.6. Гар угаах, халдвартгүйжүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

3.10.7. Бохирлогдсон хувийн хамгаалах хувцас, бусад хог хаягдлыг халдвартгүйжүүлэн устгахаар зөөвөрлөх, эсвэл шатааж устгах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

3.11. "Ногоон бүс"-д тавигдах шаардлага

3.11.1. Бүсийг тодорхойлсон тэмдэг, тэмдэглэгээтэй байна.

3.11.2. Уг бүсэд байрлах хилийн хяналтын байгууллагын ажлын өрөө, тасалгаа, хурлын заал, амрах байр, бусад үйлчилгээний газар, ундны ус нь халварын эрсдэлгүй байна.

3.11.3. Уг бүсэд нэвтрэхээс өмнө албан хаагч, ажилтан, иргэдийн биеийн халууныг хэмжих, гарыг ариутгах, хувцас, эд зүйлсийг халдвартгүйжүүлэх төхөөрөмжийг байрлуулсан байна.

3.11.4. Тухайн бүсэд эмнэлгийн тусламж үзүүлэх эмч, мэргэжилтэн байрлаж ажиллана.

3.11.5. Улаан, шар бүс дэх үйл ажиллагааг хянах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

## ДӨРӨВ. ХИЛИЙН ХЯНАЛТЫН БОЛОН БУСАД БАЙГУУЛЛАГЫН ҮҮРЭГ

4.1. Нийтлэг үүрэг:

4.1.1. Халдвараас сэргийлэх хамгаалалтын бүсэд ажиллах ажилтан, албан хаагч нь халдвараас сэргийлэх дэглэмийг баримтлан мэргэжлийн байгууллагаас гаргасан зөвлөмжийн дагуу хувийн хамгаалах хувцас хэрэгслийг хэрэглэнэ.

4.1.2. Хилийн боомт, гүний хяналтын бүсэд тусгай чиг үүргийн болон эрүүл мэндийн байгууллагын нэвтрэх, шуурхай үйл ажиллагааг хамтран зохион байгуулахад дэмжлэг үзүүлнэ.

4.1.3. Хилийн хяналтын байгууллага нь баримт бичгийн /зорчигчийн эрүүл мэндийн мэдүүлэг, орох, гарах хуудас, виз, гаалийн мэдүүлэг, тусгай зөвшөөрөл, экспорт, импортын гэрчилгээ, мэдэгдэл, тээврийн баримт, гадаад худалдааны дагалдах баримт бичиг г.м/ хяналт шалгалтыг цахим хэлбэрт шат дараатайгаар шилжүүлнэ.

4.1.4. Ажилтнуудыг хувийн хамгаалах хувцас хэрэгсэл /амны хаалт, бээлий, нүдний шил, комбинзон, углааш г.м/, спиртэн суурьтай гар халдвартгүйжүүлэгч бодисоор тогтмол хангана.

4.1.5.Ажилтан, албан хаагчдыг халдвараас сэргийлэх дэглэмийн талаарх болон хувийн хамгаалах хувцас хэрэгсэл өмсөх, тайлах сургалтад хамруулан мэдлэг, дадал олгоно.

4.1.6.Зорчигч, үйлчлүүлэгчдийг Коронавируст халдварт (КОВИД-19)-ын үед хийгдэж буй үйл ажиллагааны мэдээ, мэдээллээр хангаж, тогтмол шинэчлэнэ.

4.1.7.Зорчигч, үйлчлүүлэгчдийн хөдөлгөөнийг аль болох бөөгнөрөл дараалал үүсгэхгүй, зорчигчийн явах урсгал чиглэлийг ойлгомжтой тэмдэг тэмдэглэгээ, шалны зураас, туузан бүстэй хаалт зэрэгээр хязгаарлаж, спиртэн суурьтай гар халдвартгүйжүүлэх бодисыг хангалттай, ил харагдахуйцаар, зөвлөмж, сээрэмжлүүлэг, хүн хоорондын зайд /1.5-2 м/ барих санамжуудыг байршуулна.

4.1.8.Мэргэжлийн байгууллагын зөвлөсөн халдвартгүйжүүлэх бодис, уусмалыг холбогдох зааврын дагуу зөв найруулж, халдвартгүйжүүлэлтэд хэрэглэнэ.

4.1.9.Шат, шатны бариул, цахилгаан шатны товчуур, хаалганы бариул, сандал, тээшний тэргэнцэр, бие засах өрөө гэх мэт хамгийн их бохирдох эрсдэлтэй хэсгүүдийн цэвэрлэгээний давтамжийг нэмэгдүүлнэ.

4.1.10.Боомт болон гаалийн хяналтын бүс дэх барилга байгууламжид хийгдэх урьдчилан сэргийлэх халдвартгүйжүүлэлтийг тухайн байршилд үйл ажиллагаа явуулж буй байгууллага хариуцах ба голомтын халдвартгүйжүүлэлтийг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж, мэргэжлийн хяналтын байгууллага хяналт тавина.

4.1.11.Байгууллагууд “Халдвараас сэргийлэх хамгаалалтын бүс”-д ажил үүрэг гүйцэтгэх бие бүрэлдэхүүний талаарх мэдээллийг мэргэжлийн хяналтын байгууллагад өгнө.

4.1.12.“Халдвараас сэргийлэх хамгаалалтын бүс”-д ажиллах ажилтан, албан хаагчид нь хувийн хамгаалах хувцас хэрэгслийг бүрэн солихгүйгээр /улаан бүсээс ногоон бүс рүү/ бүс дамжихгүй байна.

4.1.13.Хилийн боомт, гүний хяналтын бүсэд ажилтан албан хаагчдын эрүүл мэндийг хянах явцад халдварын шинж тэмдэг илэрвэл нэн даруй харьяа эрүүл мэндийн байгууллагад мэдэгдэж, хариу арга хэмжээ авна.

4.1.14.Хилийн хяналтын болон эрх бүхий байгууллагын албан хаагчид нь хяналт шалгалт хийхдээ шалгуулагчийг амны хаалт зүүсэн байхыг шаардах бөгөөд аюулгүйн зайд баримтлана.

4.1.15.Ажилтан, албан хаагчид нь “Халдвараас сэргийлэх хамгаалалтын бүс”-ийн дэглэм зөрчсөн гэж үзсэн тохиолдолд нэн даруй мэргэжлийн хяналтын байгууллагын ажилтанд мэдэгдэн яаралтай арга хэмжээ авна.

4.1.16.Хилийн хяналтын байгууллагын болон эрх бүхий ажилтан, албан хаагчид нь “Нэг үйлчлүүлэгчид нэг бээлий” зарчмыг баримтлан зорчигч, бараа, тээврийн хэрэгсэлд үзлэг, шалгалт хийнэ.

4.1.17. Халдвартай хог хаягдлыг цуглуулах, түр хадгалах, устгах зохицуулалттай байна.

## 4.2. Мэргэжлийн хяналтын байгууллагын үүрэг

4.2.1. Улсын хилээр нэвтрэх зорчигч /жолооч/ нь коронавируст халдварыг илрүүлэх ПГУ /полимеразын гинжин урвал/-ын 72 цагийн болон түргэвчилсэн оношлуурын 48 цагийн “сөрөг” гарсан хариутай, уг халдварын эсрэг дархлаажуулалтын бүрэн тун авсан гэрчилгээтэй, түүнчлэн өвчлөөд эдгэрч, эсрэг бие үүссэн тухай нотлох баримт бичигтэй эсэхэд хяналт тавина.

4.2.2. Эцэг эхийн хамт яваа 0-5 насны хүүхдээс коронавируст халдварыг илрүүлэх шинжилгээ шаардахгүй бөгөөд эцэг эхээс өөр асран хамгаалагчтайгаа зорчих тохиолдолд шинжилгээний баримт бичгийг шаардана.

4.2.3. Сэжигтэй тохиолдол, ойрын хавьтлыг нийслэлд Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Шуурхай хариу арга хэмжээний багт, аймаг, орон нутагт эрүүл мэндийн байгууллагын Хариу арга хэмжээний багт мэдэгдэж, шилжүүлэх асуудлыг шийдвэрлүүлнэ.

4.2.4. Хилийн боомт, гүний хяналтын бүсэд сэжигтэй зорчигчийг түр тусгаарлах өрөөнд шаардлагатай тоног төхөөрөмж, хувийн хамгаалах хувцас, хэрэгсэл, ариутгал, халдвартгүйжүүлэлтийн багаж, бодис, эмийн нөөцийг бүрдүүлж, бэлэн байдлыг хангана.

4.2.5. Улсын хилээр нэвтэрч буй тээврийн хэрэгсэл, бараа, ачаа тээш, шуудангийн илгээмж, шарил, амьд мал, амьтан зэрэгт халдвартгүйжүүлэлтийг зохион байгуулж, хяналт тавина.

4.2.6. “Халдвараас сэргийлэх хамгаалалтын бүс”-д халдвараас сэргийлэх дэглэмийг мөрдүүлж, удирдан зохион байгуулна.

4.2.7. Хилийн боомт, гүний хяналтын бүсэд халдвараас сэргийлэх дэглэмийг хангуулах чиглэлээр мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.

4.2.8. Халдвараас урьдчилан сэргийлэх зөвлөмж, сээрэмжлүүлэг мэдээллээр зорчигч, хилийн хяналтын болон бусад байгууллагыг тогтмол хангаж ажиллана.

4.2.9. Шуурхай хариу арга хэмжээ авах чиглэлээр мэргэжлийн болон хилийн хяналтын байгууллагатай хамтран сургалт, дадлага сургуулилтыг тогтмол зохион байгуулна.

4.2.10. Хил залгаа улсын хорио цээрийн хяналтын байгууллагатай өвчний нөхцөл байдал, авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаарх мэдээллийг солилцож, хамтарсан арга хэмжээг төлөвлөж ажиллана.

4.2.11. Түр хугацаагаар болон байнга оршин суух гадаадын иргэдээс вакцин хийлгэсэн буюу урьдчилан сэргийлэх бусад арга хэмжээнд хамрагдсан тухай нотолгоо болох эрүүл мэндийн баримт бичгийг шалгана. Уг баримт бичиг нь хуурамч болон шаардлага хангаагүй тохиолдолд буцаах асуудлыг хилийн боомтын зөвлөлд танилцуулж, шийдвэрлэнэ.

4.2.12. Тухайн боомт, гаалийн хяналтын бүсийн онцлогт тохирсон халдвараас сэргийлэх дэглэмийг нарийвчлан тусгасан зааврыг боловсруулан, боомтын зөвлөлийн даргаар батлуулж, мөрдүүлнэ.

4.3. Хил хамгаалах байгууллагын үүрэг

4.3.1. Улсын хилээр Коронавируст халдвартыг илрүүлэх ПГУ /полимеразын гинжин урвал/-ын шинжилгээгээр болон түргэвчилсэн оношлуураар "серөг" гарсан, дархлаажуулалтын бүрэн тун авсан, өвчлөөд эдгэрсэн тухай нотлох баримт бичигтэй иргэнийг нэвтрүүлнэ.

4.3.2. Хилийн боомтоор улсын хил нэвтрэх зорчигч тээврийн хөдөлгөөнийг түр зогсоосон үед Улсын онцгой комиссын зөвшөөрлийн дагуу зорчигчийг улсын хилээр нэвтрүүлнэ.

4.3.3. Халдвартын сэжигтэй зорчигч ирсэн тээврийн хэрэгслийн үзлэг шалгалтыг халдвараас сэргийлэх дэглэмийг баримтлан мэргэжлийн хяналтын байгууллагатай хамтран зохион байгуулна.

4.3.4. Мэргэжлийн хяналтын байгууллагаас халдвартын сэжигтэй зорчигч, ойрын хавьтлыг илрүүлэн хариу арга хэмжээний багт шилжүүлэх тохиолдолд зорчигчийн хил нэвтрэх эрхийн баримт бичгийг хялбаршуулсан журмаар шалган нэвтрүүлнэ.

4.3.5. Халдвараас сэргийлэх хамгаалалтын бүсэд аюулгүй байдлын хяналт тавьж дэглэм сахиулахад мэргэжлийн хяналтын байгууллагад дэмжлэг үзүүлнэ.

4.3.6. Дамжин өнгөрөх зорчигчийн хөдөлгөөнд хяналт тавина.

#### 4.4. Гаалийн байгууллагын үүрэг

4.4.1. Гаалийн хяналтын бүсэд "Халдвараас сэргийлэх хамгаалалтын бүс" үүсгэхэд дэмжлэг үзүүлж ажиллана.

4.4.2. Ачаа, вагон, чингэлэгт халдвартгүйжүүлэлт хийгдсэний дараа тээврийн дагалдах бичиг баримтыг мэдүүлэгч эсхүл мэргэжлийн хяналтын байгууллагаас хүлээн авч, гаалийн хяналт, бүрдүүлэлт хийнэ.

4.4.3. Гаалийн бүрдүүлэлт, хяналт шалгалтыг хийсний дараа гаалийн хяналтын бүсээс гаргах зөвшөөрөл олгоно.

4.4.4. Урьдчилсан болон түргэвчилсэн бүрдүүлэлт шаардлагатай бараа бүтээгдэхүүнийг хилийн мэргэжлийн хяналтын байгууллагын "Хяналтад хамрагдсан тухай мэдэгдэл"-ийг үндэслэн гаалийн хяналтын бүсээс гаргана.

#### 4.5. Цагдаагийн байгууллагын үүрэг

4.5.1. Тусгаарлан ажиглах байр болон эрүүл мэндийн байгууллага хүртэл зорчигчдыг тээвэрлэх ажиллагаанд хяналт тавьж, хамгаалалтад авна.

4.5.2. Хилийн боомт, хот хооронд зорчигч, олон улсын ачаа тээвэр /дамжин өнгөрөх/, тээврийн хэрэгсэл, шаардлагатай тохиолдолд бараа бүтээгдэхүүн тээвэрлэх үед төв, суурин газруудад зогсоохгүйгээр хяналттай өртөөчлөн хүргэх, буцаах үеийн замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, хэв журмын хамгаалалт авч, хяналт тавина.

4.5.3. Зорчигч, тээврийн хэрэгсэл, бараа бүтээгдэхүүн нэвтрүүлэх явцад гэмт хэрэг, зөрчил гарсан үед халдвараас сэргийлэх дэглэмийг баримтлан, шалгах ажиллагаа явуулна.

4.5.4. Зүтгүүр, нисэх багийн бүрэлдэхүүнийг шаардлагатай тохиолдолд тусгаарлан ажиглах байранд хүргэх үеийн хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж, хяналт тавьж ажиллана.

#### **4.6. Тагнуулын байгууллагын үүрэг**

4.6.1. Хилийн хяналтын байгууллагууд чиг үүргээ хэрэгжүүлэхэд хуулиар олгогдсон эрх хэмжээний хүрээнд туслалцаа, дэмжлэг үзүүлж, хамtran ажиллана.

#### **4.7. Иргэний нисэхийн ерөнхий газрын үүрэг**

4.7.1. Нислэг давхцахгүй байх төлөвлөлтийг хийж цагийг боломжит түвшинд зохицуулна.

4.7.2. Зорчигч, тээврийн хэрэгсэл, ачаа тээврийн зохицуулалтын талаархи мэдээллийг Иргэний нисэхийн ерөнхий газар, “Нислэгийн мэдээлэл үйлчилгээний алба”-аар дамжуулан хүргэх ажлыг зохион байгуулна.

#### **4.8. Олон улсын нисэх буудлын үүрэг**

4.8.1. Ирэх болон явах зорчигч, орох, гарах хөдөлгөөнийг нэг чиглэлийн урсгалаар давхцуулахгүй байхаар зохион байгуулна.

4.8.2. Олон улсын ирэх, явах нислэгийн цагийн төлөвлөлт, зорчигчдыг агаарын хөлгөөс буулгах үеийн халдвараас сэргийлэх дэглэм зэрэг үйл ажиллагааны зохицуулалтыг хилийн хяналтын байгууллагуудтай хамtran гүйцэтгэнэ.

4.8.3. Зорчигчийн эрүүл мэндийн мэдүүлэг, гаалийн мэдүүлэх хуудсыг орох хэсэгт тарааж, бүртгэлийн танхимд хурааж авахаар төлөвлөнө.

4.8.4. Хилийн бүсэд халуурсан болон халдвартын сэжигтэй зорчигч илэрсэн тохиолдолд хөдөлгөөнийг түр хязгаарлаж, мэргэжлийн хяналтын байгууллагын зааврын дагуу ажиллана.

4.8.5. Зорчигчдын агаарын хөлөгт суух хүлээлгийн танхимд Public Address /PA/ буюу чанга яригчаар дамжуулан хоорондын зайд барих, амны хаалт зүүх гэх мэт зөвлөмж сэрэмжлүүлгийг өгнө.

4.8.6. Хүлээлгийн танхимд байх тамхи татах цэг, амралтын өрөө, хүүхдийн тоглоомын талбай, буфет хоолны газруудыг эрсдэл бууруулах арга хэмжээний үе шатуудад үндэслэн зайд барилтын хэрэгцээг хангахын тулд түр хугацаагаар хаах буюу хязгаарлагдмал хүчин чадлаар ажиллуулна.

4.8.7. Нисэх буудлын цэвэрлэгээ, халдвартгүйжүүлэх ажлыг тогтмол хийж хөдөлгөөний ачаалалтай уялдуулж давтамжийг нь нэмэгдүүлэх, бүртгэл дуусч зорчигч агаарын хөлөгт сууж, агаарын хөлөг хүзүүвчнээс салсны дараа нисэх буудлын орох хаалганаас агаарын хөлгийн хүзүүвч хүртэлх зам талбайг халдвартгүйжүүлж, цэвэрлэгээ үйлчилгээ хийнэ.

4.8.8. Аюулгүй байдлын үзлэг шалгалтын үед бээлийг тогтмол солих, бээлий тайлсны дараа гараа сайтар халдвартгүйжүүлэх, зорчигчийн биед хүрсэн үзлэг шалгалт хийхээс аль болох зайлсхийх, зайлшгүй шаардлагаар биед хүрсэн үзлэг шалгалт хийх бол халдвараас сэргийлэх дэглэмийг баримтлах, бээлийг солихгүйгээр дараагийн зорчигчийн биед хүрэхгүй байна.

4.8.9. Аюулгүй үзлэгийн тавцан, гар тээш гаргаж тавих сагс, үзлэгийн багаж хэрэгсэл зэргийг зорчигч тээшээ тавьж өнгөрөх бүрт зориулалтын сальфетка, спиртэн сууртай уусмалаар байнга халдвартгүйжүүлж ажиллана.

4.8.10. Ажилтан, албан хаагчдыг хориотой болон хамгаалагдсан бүсэд нэвтрэх, аюулгүйн үзлэг шалгалтаар ороход хаяг тэмдэглэгээтэй тусгай сагс хэрэглэнэ.

4.8.11. Аюулгүй байдлын үзлэг шалгалтын үед хэрэглэсэн бээлий, амны хаалт, нүүрний хаалт гэх мэтийг тусгай зориулалтын уут саванд хийж битүүмжлэх, зориулалтын уут савыг хангалттай бэлтгэсэн байна.

4.8.12. Аюулгүйн үзлэгийн үед зорчигчдоос хурааж авсан эд зүйлсийг зориулалтын уут, саванд тусад нь битүүмжлэн хадгална.

#### **4.9. Төмөр замын байгууллагын үүрэг**

4.9.1. Хилийн боомтоор төмөр замын улс хоорондын болон дамжин өнгөрөх зорчигч, ачаа тээвэрлэлтийг зохион байгуулах, улсын хилээр нэвтэрч ажил үүргээ гүйцэтгэж буй төмөр замын ажилтныг коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах, сэжигтэй тохиолдол илэрсэн үед шуурхай мэдээлэх, хариу арга хэмжээ авах, төмөр замын хөдлөх бүрэлдэхүүнд халдвартгүйжүүлэлт хийнэ.

4.9.2. Хөрш улсын төмөр замын байгууллагатай тээврийн баримт бичгийг цахим хэлбэрээр солилцох, хилийн өртөөний агентыг хил нэвтрэхгүйгээр ажиллах технологийг нэвтрүүлэх чиглэлээр арга хэмжээ авч ажиллана.

4.9.3. Улсын хил нэвтрэн ажил үүрэг гүйцэтгэж байгаа төмөр замын ажилтнуудын халдвараас сэргийлэх дэглэмд тогтмол хяналт тавих камерийн системийг суурилуулж, эрх бүхий байгууллагуудыг хяналт тавих нөхцөл боломжоор хангана.

4.9.4. Ачаа, вагон, чингэлэг, зүтгүүрт техникийн эвдрэл saat ал гарсан, бусад онцгой нөхцөл үүссэн тохиолдолд халдвараас сэргийлэх дэглэмийг сахин, шаардлагатай мэргэжлийн ажилтнууд, сэлбэг хэрэгсэл, багаж тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл, хөдлөх бүрэлдэхүүнийг хилээр нэвтрүүлнэ.

4.9.5. Олон улсын ирэх, явах зорчигчийн галт тэрэгний цагийн төлөвлөлт, зорчигчдыг вагонд суулгах, буулгах, аяллын туршид халдвараас сэргийлэх дэглэмийг мөрдүүлж, хяналт тавих, хилийн хяналтын байгууллагуудтай хамтран ажиллана.

4.9.6. Зүтгүүрийн бие бүрэлдэхүүн болон зорчигчийн галт тэрэгний бригадын ажиллах технологийн картыг мөрдүүлж, батлагдсан замналын дагуу явж байгаад хяналт тавих ба ажлын технологийн картад судалгаа, шинжилгээ хийж, тээвэрлэлтийн явц, шат дамжлага бүрд гарч буй saat, хүндрэл, бэрхшээлийг тодорхойлон арилгах арга хэмжээг авна.

4.9.7. Төмөр замын байгууллага нь эрх бүхий байгууллагын ажилтанд ачаа вагон, чингэлэг, зүтгүүрт халдвартгүйжүүлэлт хийх нөхцөлийг бүрдүүлнэ.

4.9.8. Вокзал нь ирэх болон явах зорчигч, орох, гарах хөдөлгөөнийг нэг чиглэлийн урсгалаар давхцуулахгүй байхаар зохион байгуулж, цэвэрлэгээ,

халдвартгүйжүүлэх ажлыг тогтмол хийж, хөдөлгөөний ачаалалтай уялдуулж давтамжийг нь нэмэгдүүлэн хийнэ.

4.9.9. Зорчигч тээврийн хэрэгслийн тасалбарыг цахимаар худалдаалах нөхцөлийг бүрдүүлж, вакцинуулалтын бүрэн тунг авснаас хойш 14 хоногийн хугацаа өнгөрсөн, сүүлийн 4 сарын хугацаанд коронавируст халдвараар өвчилж эдгэрсэн, бх-ПГУ /полимеразын гинжин урвал/-ын шинжилгээний сөрөг /3 хоногийн хүчинтэй/, антигенд суурилсан түргэвчилсэн шинжилгээний сөрөг хариу /2 хоногийн хүчинтэй/” гэсэн нотлох баримт бичгийг үндэслэн тасалбарыг бичнэ. Зорчигчийг галт тэргэнд оруулахын өмнө баримт бичгийг шалган биеийн дулааныг хэмжиж, гарыг халдвартгүйжүүлж, амны хаалтыг солиулах арга хэмжээ авна.

4.9.10. Аяллын явцад сэжигтэй тохиолдол илэрсэн үед тухайн зорчигчийг зорчиж явсан купей болон тухайн газарт түр тусгаарлаж, 2 талын купейг суллаж, вагоны үйлчлэгч галт тэрэгний даргад мэдэгдэнэ. Халдварын сэжигтэй зорчигч гэр бүлийн гишүүдийн хамт яваа бол тэднийг хамтад нь боломжит байдлаар тусгаарлана. Галт тэрэгний дарга сэжигтэй тохиолдлын мэдээллийг авмагц эрх бүхий албан тушаалтнуудад өртөөчлөн мэдээллийг өгч мэргэжлийн байгууллагын зааврын дагуу ажиллана.

4.9.11. Зорчигчийг тасалбарт бичигдсэн суудалд суулгах, сэлгүүцэхгүй байх, купей, суудал солихгүй, бусад зорчигчтой харьцахгүй, эд зүйл солилцохгүй, хоол идэхээс бусад үед амны хаалтыг авахгүй байхыг анхааруулж, хяналт тавина. Вагоны үйлчлэгч нар цэвэр ус, цай, кофе, савласан хүнсийт гараас гардамжуулахгүйгээр тавиур ашиглан өгөх ба үйлчилгээний дараа тавиурыг тухай бүр халдвартгүйжүүлнэ.

4.9.12. Зорчигч наарт үйлчлэх вагон ресторан нь хоол хүнсний аюулгүй байдлыг хангаж, хооллох хэсэгт хүн хоорондын зайл бариулж, халдвараас сэргийлэх дэглэмийг мөрдүүлэн үйлчилгээ үзүүлнэ.

4.9.13. Зорчигчийн галт тэрэгний аяллын хугацаанд ариун цэврийн өрөөг 2 цаг тутамд, бохирдсон үед тухай бүр цэвэрлэгээ, халдвартгүйжүүлэлт хийнэ. Хана, шал, суудал зэргийг өдөрт 2-оос доошгүй удаа цэвэрлэгээ, халдвартгүйжүүлэлтийг зааврын дагуу тогтмол хийнэ. Хатуу, зөвлөн өдлэлийг зааврын дагуу халдвартгүйжүүлсний дараагаар угаалга, цэвэрлэгээнд оруулна.

4.9.14. Төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд Монгол Улсын Олон улсын гэрээ, Монгол Улс, хөрш улс хоорондын хэлэлцээр, Олон улсын эрүүл мэндийн дүрэм, Гамшигаас хамгаалах тухай хууль, Эрүүл мэндийн тухай, Эрүүл ахуйн тухай, Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг буруулах тухай, Засгийн газрын холбогдох тогтоол, Улсын онцгой комисс, Эрүүл мэндийн сайд, УБТЗ ХНН-ийн даргын баталсан тушаал шийдвэр болон бусад хууль тогтоомжийн хүрээнд технологийн горимыг боловсруулан баталж, мөрдөн ажиллана.

#### 4.10. Авто тээврийн үндэсний төвийн үүрэг

4.10.1. Халдвараас сэргийлэх дэглэмийг баримтлан авто тээврийн харилцааны тухай олон улсын гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтийг хангуулж, олон улсын тээврийн автомашины зөвшөөрлийн бичгийг шалгаж, бүртгэх, зөвшөөрлийн бичиггүй тээврийн хэрэгслийн мэдээллийг Хил хамгаалах байгууллагад өгч, холбогдох арга хэмжээг авна.

4.10.2.Хилийн хяналтын холбогдох байгууллагуудыг тээвэрлэлттэй холбоотой мэдээллээр хангаж, тухайн хилийн боомтод мөрдөгдөж буй дэглэмийн дагуу тээвэр зохион байгуулалтыг хамтран хэрэгжүүлнэ.

4.10.3.Тээвэрлэгч нарыг төрийн байгууллагуудын баталсан дүрэм, журмын талаарх мэдээлэл, тээвэрлэлт гүйцэтгэхтэй холбоотой мэргэжил арга зүйн зөвлөмжөөр хангаж, хилийн хяналтын байгууллагуудад дэмжлэг үзүүлж ажиллана.

4.10.4.Шаардлагатай тохиолдолд холбогдох дүрэм, журмыг баримтлан зорчигчдыг нэгдсэн байдлаар тээвэрлэх жолооч, тээврийн хэрэгслийн техникийн бэлэн байдлыг хангуулна.

#### **4.11.Тээвэрлэгч аж ахуйн нэгжийн үүрэг**

4.11.1.Тээвэрлэгч нь иргэд харилцан зорчих нөхцлийн талаар байгуулсан Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу визгүй зорчих, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 11.8, 15.1-д заасан шаардлагыг хангасан эсхүл Монгол Улсад нэвтрэх виз, визийн зөвшөөрөл болон оршин суух зөвшөөрөлтэй гадаадын иргэн, харьялалгүй хүнийг тээвэрлэх бөгөөд дээрх зөвшөөрөлгүй иргэнийг тээвэрлэн ирэх тохиолдолд тус улсаас буцаах асуудлыг тухайн тээвэрлэгч хариуцна. /Энэ заалт нь 2021 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжинэ/

4.11.2.Тээвэрлэгчид нь ажилтнаа коронавируст халдварт /КОВИД-19/-аас урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын бүрэн тунд хамруулна.

4.11.3.Хувийн хамгаалах хувцас хэрэгсэл болон халдвараас сэргийлэхэд шаардлагатай эм, хэрэгслээр хангана.

4.11.4.“Эрүүл мэндийн мэдүүлэг”-ийг хил нэвтрэх бүрт үнэн зөв мэдүүлэх, зорчигчдод тараах, бөглөх зааварчилгаа өгнө.

4.11.5.Зорчигчдод хэрэглүүлэх нөөц амны хаалт, хог хаягдал цуглуулах шар уут, хогийн савыг шаардлагатай цэгүүдэд хүрэлцэхүйц хэмжээгээр байрлуулна.

4.11.6.Тээврийн хэрэгслийг хилийн боомтын нэвтрэх цэг болон бусад тогтоосон цэгт зогсоож халдвартайжүүлэлт, хяналт шалгалтыг хийлгэнэ.

4.11.7.Дамжин өнгөрөх зорчигчийн мэдээллийг хил хамгаалах байгууллагад өгч, хөдөлгөөнд хяналт тавина.

#### **4.12.Агаарын замаар тээвэрлэгчийн үүрэг**

4.12.1.Гадаадын авиа компанийн төлөөлөгчийн газар нь “Зорчигчийн эрүүл мэндийн мэдүүлэг”-ийн хуудсыг урьдчилан цахимаар илгээж, хувилан нислэгийн явцад тараах, зорчигчдоор бөглүүлэх асуудлыг хариуцах, цахим системийг хэрэглээнд нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

4.12.2.Гадны авиа компанийн экипаж солигдох үед халдвараас сэргийлэх дэглэмийн дагуу тусгаарлан ажиглах байр, хамгаалалт болон тусгаарлалттай холбоотой үүсэх асуудлыг тухайн авиа компани хариуцна.

4.12.3.Агаарын хөлгийн ариун цэврийн өрөөнд гар угаах шингэн саван, цаасан алчуур, гар халдвартайжүүлэгчийг тухайн нислэгт хүрэлцэхүйц хэмжээгээр байрлуулна.

4.12.4. Зорчигчид буусны дараа нисгэгчийн болон зорчигчийн бүхээгт тухайн агаарын хөлгийн үйлдвэрлэгч (Boeing, Fokker, Embraer г.м.) болон холбогдох олон улсын байгууллага (ICAO, IATA)-ын стандарт, зөвлөмжийн дагуу халдваргүйжүүлэлт хийх журам, бодис, тоног төхөөрөмжийг бэлтгэсэн байна.

4.12.5. Гадаад улсаас ирэх зорчигчдыг бүртгэх үед дархлаажуулалтын бүрэн тун хийлгэсэн эсэх, 72 цагийн болон түргэвчилсэн оношлуурын 48 цагийн "сөрөг" гарсан хариутай эсэх, дамжин өнгөрсөн улс зэрэг мэдээллээр мэргэжлийн хяналтын байгууллагыг хангана.

4.12.6. Агаарын хөлөг газардах үед зорчигчдын нэrsийг дуудах хүrtэл суудалдаа сууж байх, буухад хэрэгжүүлэх арга хэмжээний талаар зарлан мэдээлэл өгсөн байна.

#### 4.13. Авто замаар тээвэрлэгчийн үүрэг

4.13.1. Автотээврийн харилцааны тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу зөвшөөрлийн бичгийг авсан байна.

4.13.2. Тээврийн хэрэгсэл нь Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, стандартыг бүрэн хангана.

4.13.3. Тээвэр гүйцэтгэгчдийг бүртгэлжүүлж, тогтоосон тусгаарлалтын бүсийн дэглэмийг мөрдөнө.

#### 4.14. Хилийн бүсэд үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, иргэний үүрэг

4.14.1. Аж ахуйн нэгж байгууллагын ажилтнууд нь боомтын цагийн хуваарийн дагуу үйл ажиллагаа явуулж, халдвар хамгааллын дэглэмийг чанд баримтална.

#### 4.15. Эрүүл мэндийн байгууллагын үүрэг

4.15.1. Улсын хилээр нэвтрэсэн зорчигчдоос сэжигтэй тохиолдол илэрсэн үед /Нийслэлд ХӨСҮТ, орон нутагт харьяа эрүүл мэндийн байгууллага/ хариу арга хэмжээний шуурхай багийг илгээж, сэжигтэй тохиолдол болон ойрын хавьтад тандалт судалгаа хийн, эмнэлэгт хүлээн авах асуудлыг шийдвэрлэнэ.

4.15.2. Хилийн боомтын ажилтан, албан хаагчдын дунд халдварт өвчний сэжигтэй тохиолдол илэрсэн үед хариу арга хэмжээг хилийн хяналтын байгууллагуудтай хамтран шуурхай авч хэрэгжүүлнэ.

4.15.3. Зорчигч, үйлчлүүлэгчдэд эрүүл мэндийн яаралтай тусlamж шаардлагатай тохиолдолд тухайн боомт хариуцсан эмч, эрүүл мэндийн байгууллага эмнэлгийн тусlamж үзүүлнэ.

4.15.4. Хилээр нэвтрэх зорчигчдын коронавируст халдвар (Ковид-19)-аар өвдөөд эдгэрсэн тухай болон дархлаажуулалтын гэрчилгээнд тавигдах шаардлагын талаар зөвлөмж өгнө.

4.15.5. Холбогдох байгууллагуудыг Коронавируст халдвар (Ковид-19)-ын хувирсан /мутацлагдсан/ хэлбэр бүртгэгдсэн улс орнуудын талаарх мэдээллээр тогтмол хангана

#### 4.16. Онцгой байдлын байгууллагын үүрэг

4.16.1. Хилийн боомтод гал түймэр, осол гарсан үед гал түймрийг унтраах, аврах ажиллагааг зохион байгуулна.

#### 4.17. Иргэний үүрэг

4.17.1. “Эрүүл мэндийн мэдүүлэг”-ийн хуудсыг үнэн зөв бөглөнө.

4.17.2. Коронавируст халдварт (Ковид-19) илрүүлэх ПГУ-ын шинжилгээ, эсрэг бие илрүүлэх шинжилгээ, Коронавируст халдварт (Ковид-19)-ын эсрэг дархлаажуулалтад хамрагдсан гэрчилгээ, өвчлөөд эдгэрсэн тухай нотлох баримт /тухайн улсын эрх бүхий байгууллагын хүлээн зөвшөөрөгдсөн/ зэргийг хилийн хяналтын байгууллагад шалгуулна.

4.17.3. Хилийн хяналтын болон тээвэрлэгчдийн тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлнэ.

### ТАВ. ХИЛИЙН БООМТООР ЗОРЧИГЧ, ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ, БАРААГ НЭВТРҮҮЛЭХ ҮЕИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТ

#### 5.1. Зорчигчийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хяналт шалгалт

5.1.1. Улсын хилээр нэвтрэх зорчигч нь ПГУ шинжилгээний 72 цагийн, хүүхэд, жолооч нар нь түргэвчилсэн шинжилгээний 48 цагийн “сөрөг” хариутай байж болно.

5.1.2. Гэр бүлийн хамт яваа 0-5 насны хүүхдээс коронавируст халдварт илрүүлэх шинжилгээ шаардахгүй.

5.1.3. Улсын хилээр орох зорчигч нь коронавируст халдвартын эсрэг дархлаажуулалтын бүрэн тунд хамрагдсанаас хойш 14 хоног өнгөрсөн эсхүл сүүлийн 4 сарын хугацаанд өвчлөөд эдгэрсэн тухай нотломжтой бол тусгаарлан ажиглах байр луу шилжүүлэхгүй, хэвийн горимоор нэвтрүүлнэ.

5.1.4. Иргэд харилцан зорчих нөхцөлийн талаар байгуулсан Засгийн газар хоорондын хэллэлцээрийн дагуу визгүй зорчилоос бусад Монгол Улсад нэвтрэх гадаадын иргэн, харьяалалгүй хүн нь Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 11.8, 15.1-д заасан шаардлагыг хангасан эсхүл Монгол Улсад нэвтрэх виз, визийн зөвшөөрөл болон оршин суух зөвшөөрөлтэй байна. /Энэ заалтыг 2021 оны 06 дугаар сарын 01-ээс хэрэгжиж өхэлнэ./

5.1.5. Мэргэжлийн хяналтын байгууллага 5.1.1, 5.1.3-д заасан баримт бичгийг шалган, зорчигчийн эрүүл мэндийн тандалт хийж, тусгаарлан ажиглалтад шилжүүлэх зорчигчдыг тодорхойлж, холбогдох байгууллагад мэдэгдэнэ.

5.1.6. Мэргэжлийн хяналтын байгууллагын хяналт тандалтаар халдвартын сэжигтэй зорчигч илрээгүй бол бусад хилийн хяналтын байгууллагын үзлэг шалгалтыг эхлүүлж болох тухай мэдээллийг хил хамгаалах байгууллагад өгнө.

5.1.7. Хилийн боомтоор улсын хил нэвтрэх зорчигч, тээврийн хөдөлгөөнийг түр зогсоосон үед Улсын онцгой комиссын зөвшөөрлийн дагуу зорчигчийг улсын хилээр нэвтрүүлнэ.

5.1.8. Улсын хилээр нэвтрэх шарил, чандрыг халдваргүйжүүлсний дараа чандрыг хүлээн авагчид, шарилыг тухайн хүний нас барсан шалгааныг тогтоож эруул мэндийн байгууллагад хүлээлгэн өгнө.

5.1.9. Коронавируст халдварын шалгаанаар нас барсан хүний шарилыг Улсын онцгой комиссын шийдвэрийг үндэслэн хилээр нэвтрүүлнэ.

5.2. Тээврийн хэрэгсэл, бараа, амьд мал, амьтан улсын хилээр нэвтрүүлэх үеийн хяналт шалгалт

5.2.1. Монгол Улсын Засгийн газар, Улсын онцгой комиссоос гаргасан шийдвэрийн дагуу тээврийн хэрэгсэл, барааг хилийн боомтоор нэвтрүүлнэ.

5.2.2. Улс хоорондын ачаа тээвэрлэлтийн үйл ажиллагаа нь Монгол Улсын олон улсын гэрээ, хэлэлцээрт нийцсэн байна.

5.2.3. Улс хоорондын ачаа тээвэрлэлтэд оролцож буй автотээврийн хэрэгсэл нь Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу тээвэрлэлт гүйцэтгэх зөвшөөрлийн бичигтэй байна.

5.2.4. Хил залгаа улсын хилийн боомтоос татан авах тээврийн хэрэгслийг Улсын онцгой комиссын зөвшөөрлийн дагуу халдвараас сэргийлэх дэглэмийг чанд мөрдүүлэн хилийн боомтын зөвлөл зохион байгуулна.

5.2.5. Эрүүл мэндийн хяналт тандалтаар барааг тээвэрлэж буй гадаад жолоочид халдварын шинж тэмдэг илэрвэл ТИР конвенц болон тухайн улстай хийсэн автотээврийн хэлэлцээрийн дагуу холбогдох байгууллагад мэдээлж, мэргэжлийн байгууллагатай хамтарсан хариу арга хэмжээг авна.

5.2.6. Улсын хилээр нэвтэрч буй тээврийн хэрэгслийн халдваргүйжүүлэлтийг мэргэжлийн байгууллагаас баталсан журмын дагуу хийнэ.

5.2.7. Хүнсний бүтээгдэхүүн тээвэрлэж буй улс хоорондын тээврийн хэрэгсэлд Олон улсын эрүүл мэндийн дүрмийн хавсралт 4-д заасан шаардлагыг ханггуулж, халдваргүйжүүлэлт хийсэн гэрчилгээтэй байна.

5.2.8. Коронавируст халдварын эсрэг вакцины сав баглаа боодлыг халдваргүйжүүлсний дараа дагалдах баримт бичгийг хянаж, гаалийн түргэвчилсэн бүрдүүлэлт хийн, үйлдвэрлэгчийн заасан хадгалалтын горимоос хамаарч шалгалтыг гаалийн хяналтын бус болон вакциныг хадгалах зориулалтын агуулахад хийнэ.

5.2.9. Коронавируст халдварын үед улсын хилээр гэрийн тэжээвэр амьтныг нэвтрүүлэхэд Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2020 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн “COVID-19 цар тахлын онцгой нөхцөлд улсын хилээр нохой, муур нэвтрүүлэх, мал эмнэлгийн тусгаарлалтын хяналтад авах түр заавар”-ыг баримтална.

5.2.10. Коронавируст халдварын цар тахлын үед улсын хилээр импортлох амьд мал, амьтанд Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт шалгалтын тухай хуулийн 23 дугаар зүйлд заасны дагуу “Импортын мэдэгдэл” олгож, тухайн орон нутагт 21 хоног хүртэлх хугацаагаар тусгаарлана.

## ЗУРГАА. БУСАД

6.1. Энэ журам нь Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн хүчин төгөлдөр үйлчилнэ.

6.2. Энэ журмыг зөрчсөн иргэн, хуулийн этгээд, аж ахуйн нэгж, байгууллага, тэдгээрийн эрх бүхий албан тушаалтан, ажилтан, иргэдэд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

6.3. Энэ журмаар зохицуулагдаагүй асуудлыг Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 9.8-д заасны дагуу тусгай журамд тусган мөрдөнө.

6.4. Улсын хилийн боомт, боомтоос гадуурх гаалийн хяналтын бүс дэх тээврийн хэрэгсэл, ачаа тээшний халдвартгүйжүүлэлтийг эрүүл мэндийн болон мэргэжлийн хяналтын байгууллагаас гаргасан холбогдох журам, зааварт нийцүүлэн хийнэ.

6.5. Энэ журмыг нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн бусад олон улсын хөл хориот өвчний үед дүйцүүлэн мөрдөж болно.

---oOo---

Монгол Улсын Шадар сайдын 2021 оны  
26 дугаар сарын 24-ны өдрийн... дугаар  
тушаалын хоёрдугаар хавсралт

ОЛОН УЛСЫН ЗОРЧИГЧ, АЧАА ТЭЭВРИЙН НИСЛЭГИЙН  
ҮЕД ХЭРЭГЖҮҮЛЭХ ХАЛДВАРААС СЭРГИЙЛЭХ ХАРИУ  
АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗААВАР

Нэг. Олон улсын зорчигч тээврийн нислэгийн үед хэрэгжүүлэх халдвараас  
сэргийлэх хариу арга хэмжээ

1.1. Олон улсын агаарын хөлөгт зорчигч суулгах, нислэгийн явцад авч  
хэрэгжүүлэх арга хэмжээ

1.1.1. Зорчигчийг агаарын хөлөгт оруулахын өмнө биеийн дулааныг хэмжиж,  
“Зорчигчийн эрүүл мэндийн мэдүүлэг”-ээр тандалт хийн /ирэх чиглэлийн нислэгт  
тандалтыг нислэгийн явцад болон газардсаны дараа хийх/, гарыг  
халдвартайжүүлж, амны хаалтыг солиулна.

1.1.2. Зорчигчийн биеийн дулааны хэмжилтээр  $37.1^{\circ}\text{C}$ -ээс дээш халуурсан  
болон халдварт өвчний шинж тэмдэг бүхий зорчигч илэрсэн тохиолдолд ирэх  
чиглэлийн нислэгт агаарын хөлгийн даргад /гадны авиа компанийн төлөөлөгч/,  
явах чиглэлийн нислэгт мэргэжлийн хяналтын байгууллагад мэдэгдэж, эрх бүхий  
байгууллагын өгсөн чиглэлийн дагуу тухайн зорчигчийг агаарын хөлөгт оруулах  
эсэх асуудлыг шийдвэрлэнэ.

1.1.3. Зорчигчийг тасалбарт бичигдсэн суудалд суулгах, онцын  
шаардлагагүй бол босч явахгүй, суудал солихгүй, бусад зорчигчтой харьцахгүй, эд  
зүйл солилцохгүй, хоол идэхээс бусад үед амны хаалтыг авахгүй байхыг агаарын  
хөлгийн дотуур холбоогоор анхааруулж, хяналт тавина.

1.1.4. Нислэгийн үеэр зорчигчийн биеийн халууны хэмжилтээр  $37.1^{\circ}\text{C}$ -ээс  
дээш халуурсан тохиолдолд З удаагийн давтамжтайгаар хэмжилт хийж, халуунтай  
нь тогтоогдох буюу “Халдвартын сэжигтэй тохиолдол”-д тооцох шинж тэмдэг  
илэрвэл бусад зорчигчдоос боломжит байдлаар тусгаарлах арга хэмжээг авна.

1.1.5. Халдвартын сэжигтэй зорчигч илэрсэн тохиолдолд тухайн зорчигчид  
хамгийн ойр зайнд байрлах агаарын хөлгийн ариун цэврийн өрөөг нислэгийн турш  
ашиглуулахаар тусгайлан бэлдэнэ.

1.1.6. Халдвартын сэжигтэй зорчигч гэр бүлийн гишүүдийн хамт яваа бол  
тэднийг хамтад нь боломжит байдлаар тусгаарлана.

1.1.7. Зорчигч ариун цэврийн өрөөг ашиглах бүрт тусгайлан томилогдсон  
агаарын хөлгийн үйлчлэгч нь ариун цэврийн өрөө /толь, шүүгээ, угаалтуур,  
суултуур, дэлгэгддэг тавиур, тааз, хана, шал г.м/-г зориулалтын бодисоор  
халдвартайжүүлнэ.

1.1.8. Зорчигчдын амны хаалтыг 2-3 цаг тутамд, бохирлогдсон тохиолдолд  
тухай бүр солиулах ба бохир амны хаалтыг суудлын урд байрлах цаасан уутанд  
хийж, шар өнгийн хогийн уутанд цуглуван.

1.1.9. Хог хаягдлыг шар өнгийн уутанд цуглуван сайтар битүүмжилнэ.

1.1.10. Цэвэр ус, савласан хүнсийг гараас гарт дамжуулахгүйгээр тавиур ашиглан өгөх ба үйлчилгээний дараа тавиурыг халдвартгүйжүүлнэ.

## **1.2. Монгол Улсын агаарын хилээр зорчигч, тээврийн хэрэгсэл нэвтрэх үед авч хэрэгжүүлэх хариу арга хэмжээ**

1.2.1. Агаарын хөлөг газардахаас 15 минутын өмнө халдвараас сэргийлэх хариу арга хэмжээний баг /4-6 улсын байцаагчдаас бүрдсэн/ хувийн хамгаалах хувцас хэрэгслийг өмсөж, сагсанд зайнлас халуун хэмжигч, бал, спирттэй хөвөн, устөрөгчийн хэт исэл бүхий сальфетка, нөөц зорчигчийн эрүүл мэндийн мэдүүлгийн хуудас болон бээлий зэргийг бэлтгэсэн байна.

1.2.2. “Зорчигчийн урьдчилсан мэдээлэл авах систем”-ээс мэдээллийг авч төлөвлөлт хийсэн байна.

1.2.3. Агаарын хөлгийн бүхээгийн ахлах ажилтнаас, /гадаадын авиа компанийн төлөөлөгчөөр дамжуулан/ зорчигчийн эрүүл мэндийн ерөнхий мэдүүлэг, /general declaration form/ зорчигчдын тоо, суудлын дугаар бүхий нэrsийн жагсаалт, коронавируст халдварт (КОВИД-19)-ын эсрэг дархлаажуулалтын бүрэн тун авсан болон өвчлөөд эдгэрсэн зорчигчдын мэдээлэл, онцлог ачаа тээшний талаарх мэдээлэл /шарил, чандар, гэрийн тэжээвэр амьтан, тээвэрлэлтийн тусгай горим шаардсан бүтээгдэхүүн г.м/ -ийн хамт авч, хяналт тандалт хийх төлөвлөлтийг хийнэ.

1.2.4. Зорчигч, нисэх багаас эрүүл мэндийн мэдүүлгээр тандалт хийх явцдаа биеийн дулааныг хэмжиж тэмдэглэнэ.

1.2.5. Зорчигчийн коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын бүрэн тун хийлгэсэн, өвчлөөд эдгэрсэн эсхүл ПГУ /полимеразын гинжин урвал/-ын болон түргэвчилсэн шинжилгээний дүнтэй эсэхийг шалгана.

## **1.3. Мэргэжлийн хяналтын улсын байцаагч нислэгийн явцад хэрэгжүүлэх арга хэмжээ /Тусгай үүргийн нислэгт томилогдох үед/**

1.3.1. Нислэгт явах улсын байцаагчид нислэг эхлэхээс 2 цагийн өмнө нисэх багт “Нислэгийн өмнөх яриа”-ны үеэр цаг үеийн нөхцөл байдал, халдвараас сэргийлэх хариу арга хэмжээний талаар мэдээлэл өгч баталгаажуулна.

1.3.2. Бүхээгийн ажилтнууд, мэргэжлийн хяналтын улсын байцаагч болон томилогдсон бусад ажилтан /инженер, техникийн ажилтан г.м/ нь коронавируст халдварт (КОВИД-19)-аас сэргийлэх дархлаажуулалтын бүрэн тунг хийлгээгүй тохиолдолд зорчигчдыг агаарын хөлөгт суухын өмнө хувийн хамгаалах хувцас хэрэгслийг зааврын дагуу өмссөн байна.

1.3.3. Нисгэх багийхан нь зорчигчид агаарын хөлөгт суухаас өмнө бүхээгт орсон байх ба хувийн хамгаалах хэрэгслийг /амны хаалт, 1 удаагийн бээлий, шаардлагатай тохиолдолд ашиглах иж бүрэн хувийн хамгаалах хувцас хэрэгсэл/ бэлтгэсэн байна.

1.3.4. Мэргэжлийн хяналтын улсын байцаагч нь агаарын хөлгөөс зорчигчид бүрэн буусны дараа агаарын хөлөгт хийгдэх халдвартгүйжүүлэлт, цэвэрлэгээ үйлчилгээнд хяналт тавина.

1.3.5. Мэргэжлийн хяналтын улсын байцаагч нь ирэх чиглэлийн зорчигчдыг агаарын хөлөгт суухаас өмнө тухайн улс орон дахь төлөөлөгч эсхүл элчин сайдын

яамны ажилтнаас зорчигчид урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын бүрэн тунг авсан эсэх, өвчлөөд эдгэрсэн эсхүл ПГУ / полимеразын гинжин урвал/-ын шинжилгээ болон түргэвчилсэн оношлуураар "сөрөг" гарсан хариутай эсэх зэрэг мэдээллийг авч, урьдчилан төлөвлөлт хийнэ.

1.3.6.Мэргэжлийн хяналтын улсын байцаагч нь агаарын хөлөг хөөрсний дараа тандалт хийнэ.

1.3.7.Халдвартын сэжигтэй тохиолдлыг агаарын хөлгийн даргад дотуур холбоогоор мэдээллэж, агаарын хөлгийн дарга нь Монгол Улсын агаарын хилийн зурваст ормогц "Нислэг хөдөлгөөний үйлчилгээний алба"-нд мэдэгдэнэ.

1.3.8.Мэргэжлийн хяналтын улсын байцаагч нь зорчигчдын эрүүл мэндийн мэдүүлгийн хуудас болон холбогдох бусад баримт бичгийг шар өнгийн уутанд цуглуулж, битүүмжилнэ.

#### **1.4.Агаарын хөлгөөс нисгэх баг, зорчигчид, бүхээгийн ажилтнуудыг буулгах**

1.4.1.Нисгэх баг нь эхэлж агаарын хөлгөөс буух /гадаадын авиа компанийн буцах нисэх багт хамаarahгүй/ ба шар бүсэд хамгаалах хувцас, хэрэгслийг зааврын дагуу тайлж, хувийн эд зүйлс болон гарыг халдвартайжүүлсний дараа ногоон бүсэд шилжинэ.

1.4.2.Гадаадын авиа компанийн нисэх баг солигдох үед халдвараас сэргийлэх дэглэмийн дагуу тусгаарлан ажиглах байранд дараагийн нислэг хүртэл тусгаарлагдана. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг дархлаажуулалтын бүрэн тун авсан, өвчлөөд эдгэрсэн тухай нотломжтой нисэх багт хамаarahгүй.

1.4.3.Зорчигчдыг 1-т "халдвартын сэжигтэй", 2-т "ойрын хавьтал ", 3-т "эрүүл мэндийн шалтгаантай болон түүний асран хамгаалагч", 4-т дамжин өнгөрөх, 5-т "бусад" гэсэн дарааллаар агаарын хөлгөөс буулгах эрэмбэлэн ангилалтыг хийж, цагдаагийн байгууллагын хамгаалалтад шилжүүлнэ.

1.4.4.Коронавируст халдварын сэжигтэй зорчигч илэрсэн тохиолдолд бусад зорчигчдоос түр тусгаарлан, холбогдох байгууллагад мэдэгдэж чиглэл авна.

1.4.5.Халдвартын сэжигтэй зорчигч болон ойрын хавьтлыг шилжүүлэх тохиолдолд агаарын хөлгийн хойд хаалгаар буулгаж, эрүүл мэндийн байгууллагын хариу арга хэмжээний багт шилжүүлнэ.

1.4.6.Эрүүл мэндийн шалтгаантай зорчигч /асран хамгаалагч/-ийг агаарын хөлгийн урд хаалгаар хуваарилсан тээврийн хэрэгсэлд суулган, эрүүл мэндийн байгууллагад шилжүүлнэ.

1.4.7.Дамжин өнгөрөх зорчигчдыг нисэх буудлын транзит танхимд хил хамгаалах байгууллагын хяналтад дараагийн нислэгийн авиа компани /төлөөлөгчид/-д шилжүүлнэ.

1.4.8.Зорчигчдыг тусгаарлан ажиглах байр /ТАБ/-ны хуваарилалтын дагуу тээврийн хэрэгсэлд суулгаж, цагдаагийн байгууллагын хяналтад шилжүүлнэ. /тусгаарлан ажиглах шаардлагагүй зорчигчдыг ердийн горимоор нэвтрүүлнэ/

1.4.9.Зорчигчид бүрэн бууж дууссаны дараа бүхээгийн ажилтнууд халдвараас сэргийпэх дэглэмийг зөрчөөгүй тохиолдолд шар бүсээр дамжин

хувийн хамгаалах хувцас хэрэгслийг зааврын дагуу тайлж, хувийн эд зүйлс болон гарыг халдвартгүйжүүлсний дараа ногоон бүс рүү шилжинэ.

1.4.10. Нисэх багийнхан халдвараас сэргийлэх дэглэмийг зөрчсөн тохиолдолд тусгаарлан ажиглах асуудлыг УОК-ийн ШШ-аас өгсөн чиглэлийн дагуу шийдвэрлэнэ.

1.4.11. Зорчигчийн биеэс тусдаа тээшийг /хүүхдийн тэрэг, тэргэнцэр г.м/ халдвартгүйжүүлэн шууд олгож болно.

1.4.12. Зорчигчдын тээшинд өгсөн ачааг халдвартгүйжүүлсний дараа нэгдсэн зохицуулалтаар ар гэрт нь /бирк/ тээшний баримтыг үндэслэн олгоно.

Хоёр. Олон Улсын ачаа тээврийн нислэгийн үед хэрэгжүүлэх халдвараас сэргийлэх хариу арга хэмжээ /Мэргэжлийн хяналтын улсын байцаагч яваагүй нислэгт бүхээгийн ахлах ажилтан халдвараас сэргийлэх дэглэмийн байдалд хяналт тавих/

2.1. Хилийн гарах чиглэлд ачаа тээврийн нислэгт /ачаа ачих/ авч хэрэгжүүлэх арга хэмжээ

2.1.1. Нислэгээс 1 цаг 30 минутын өмнө “Нислэгийн өмнөх яриа”-нд оролцон, цаг үеийн нөхцөл байдал, халдвараас сэргийлэх дэглэмийн талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгнө.

2.1.2. Нисэх баг, томилогдсон ажилтан /инженер, жин тонн тэнцүүлэгч, рэймп, ачигч г.м/-уудын хамгаалах хувцас хэрэгсэл, нэг удаагийн бээлий, амны хаалт, тусгай хог хаягдлын уут, халдвартгүйжүүлэх уусмал зэргийн чанар, хүрэлцээг шалгаж, шаардлага хангахгүй тохиолдолд солиулна.

2.1.3. Нислэгийн явцад нисэх баг, томилогдсон ажилтнуудын биеийн дулааныг хэмжиж, эрүүл мэндийн мэдүүлэг бөглүүлж мэргэжлийн хяналтын байгууллагад өгнө.

2.1.4. Агаарын хөлөг газардахаас 30 минутын өмнө нисэх багийн бүрэлдэхүүний хамгаалах хувцас хэрэгслийг зааврын дагуу өмсөхөд хяналт тавина.

2.1.5. Ачилтын болон нислэгийн үед нисэх баг, томилогдсон ажилтнуудын халдвараас сэргийлэх дэглэмийн байдалд хяналт тавьж, тухай бүр заавар чиглэл өгч ажиллана.

2.1.6. Ачаа ачиж дууссаны дараа ачигч нарын ажлын бээлий болон хоёрдугаар бээлийг тайлуулж, шинэ бээлий өмсгөнө.

2.1.7. Агаарын хөлөг газардаж, авиа компанийн төлөөлөгчийн оруулсан нислэгийн мэдээлэл, баримт бичиг /Notification to captain/, карго ачааны баримт бичиг /Cargo manifest/, нислэг болон техник үйлчилгээний дэвтэр /Flight maintenance logbook/, сумалгааны талон /Fueling receipt/ зэргийг халдвартгүйжүүлж агаарын хөлгийн даргад өгнө.

2.1.8. Дипломат ачаа, шуудан, комелийн гадаргууг халдвартгүйжүүлж агаарын хөлөгт оруулна.

2.1.9. Хэрэглэсэн амны хаалт, бохир бээлийг шар уутанд хийж, битүүмжилнэ.

2.2. Хилийн орох чиглэлд ачаа тээврийн нислэгт /ачаа буулгах болон транзит/ авч хэрэгжүүлэх арга хэмжээ

2.2.1. Агаарын хөлөг газардсаны дараа бүхээгийн ахлах ажилтан нь гаалийн улсын байцаагчид карго манифестыг хүлээлгэн өгч, ачаа шуудан үйлчилгээний цогцолборт үүсгэсэн шар бүсэд хувийн хамгаалах хувцас хэрэгслийг зааврын дагуу тайлан, гарыг халдвартай хэрэгжүүлэх дараа ногоон бүсрүү шилжинэ.

2.2.2. Агаарын хөлгийн зорчигчийн бүхээгийн хэсгээс ачаа буулгах тохиолдолд ачигчид ачааг буулгаж дуусаад шар бүсрүү шилжинэ.

2.2.3. Хил хамгаалах байгууллага нь агаарын хөлгийг хяналтад авч хил зөрчигч байж болзошгүй хэсэг, овор ихтэй ачаанд хялбаршуулсан журмаар хяналт шалгалтыг явуулна.

2.2.4. Агаарын хөлгийг халдвартай хэрэгжүүлж, 1 цаг хүртэл хугацаагаар битүүмжилсний дараа цэвэрлэгээ, үйлчилгээг оруулна.

2.3. Дамжин өнгөрөх ачаа тээврийн нислэгт /ачаа буулгах/ авч хэрэгжүүлэх арга хэмжээ

2.3.1. Нисэх баг, томилогдсон ажилтнууд нь амны хаалт, бээлийтэй нислэгийг үргэлжлүүлнэ.

2.3.2. Агаарын хөлөг газардахаас 30 минутын өмнө нисэх баг, томилогдсон ажилтнууд хувийн хамгаалах хувцас хэрэгслийг зааврын дагуу өмссөн байна.

2.3.3. Агаарын хөлөг газардахад гаднаас оруулах нислэгийн мэдээлэл, баримт бичиг /Notification to captain/, карго ачааны баримт бичиг /Cargo manifest/, нислэг болон техник үйлчилгээний дэвтэр /Flight maintenance logbook/, сумалгааны талон /Fueling receipt/ зэргийг халдвартай хэрэгжүүлэх дараа агаарын хөлгийн даргад өгнө.

2.3.4. Дипломат ачаа, шуудан, комел зэргийг халдвартай хэрэгжүүлж агаарын хөлөгт оруулна.

2.3.5. Ачаа буулгах явцад нисгэгчийн бүхээгийн хаалгыг нээхгүй, бүхээгийн ажилтан, томилогдсон ажилтнуудын халдвараас сэргийлэх дэглэмийн байдалд хяналт тавина.

2.3.6. Ачаа буулгаж дууссаны дараа зорчигчийн бүхээгийг мананцар үүсгэн халдвартай хэрэгжүүлнэ.

2.3.7. Нисэх баг, томилогдсон ажилтнууд хамгаалах хувцас хэрэгслийг зааврын дагуу тайлж, амны хаалт, бээлий өмсөнө.

2.3.8. Халдвартай хог хаягдалтай /хамгаалах хувцас хэрэгсэл/ уутны гадаргууг халдвартай хэрэгжүүлэх давхар уутанд хийж битүүмжилнэ.

Монгол Улсын Шадар сайдын 2021 оны  
дугаар сарын 22-ны өдрийн дугаар  
тушаалын гуравдугаар хавсралт

**ХИЛИЙН БООМТОД ХАЛДВАРААС СЭРГИЙЛЭХ ХАРИУ АРГА  
ХЭМЖЭЭНИЙ ҮЕД АЖИЛТАН, АЛБАН ХААГЧДЫН  
ХЭРЭГЛЭХ ХУВИЙН ХАМГААЛАХ ХУВЦАС  
ХЭРЭГСЛИЙН ИЖ БҮРДЛИЙН ЖАГСААЛТ**

№	Хамгаалах хувцас хэрэгслийн иж бүрдэл	Анхаарах асуудал	Тайлбар
Нисгэх баг, зүтгүүрийн бригад, жолооч /кабинаас гарагчий болон сэжиг илрээгүй тохиолдолд/			
1	1. Амны хаалт 2. Бээлий 3. Нэг удаагийн малгай	Бусад ажилтан, албан хаагчид болон зорчигчидтой шууд харилцаа үүсгэхгүй, халдвартгуйжүүлсний дараа баримт бичигтэй харьцах	Кабинаас гараг тохиолдолд улавч, нүүрний хаалт хэрэглэнэ.
Бүхээгийн болон цувааны ажилтан, халдвартгуйжүүлээгүй ачаа, тээштэй харьцах ажилтан			
2	1. Амны хаалт 2. Нүүрний хаалт эсвэл нүдний шил 3. Нэг удаагийн комбинзон 4. Бээлий 5. Нэг удаагийн малгай 6. Углааш	Зорчигч, үйлчлүүлэгчидтэй аюулгүйн зайд баримталж, үйлчилгээ үзүүлэхдээ гараас гарч дамжуулахгүй. Үйлчилгээ үзүүлсний дараа гадна бээлийг солих	
Хилийн боомтод, тээврийн хэрэгслийн гадна зохицуулах үйлчилгээ үзүүлэх ажилтан			
Хилийн боомтын нэвтрэх цэгийн талбайд тээврийн хэрэгсэл, зорчигчдын зохицуулах үйлчилгээ үзүүлэх ажилтан			
3	1. Нэг удаагийн амны хаалт 2. Бээлий		Халдвартгуйжүүлээгүй тээврийн хэрэгсэл, тээврийн хэрэгслийн бүхээг, ачаа тээш, баримт бичигтэй шууд харьцахгүй ажилтан, албан хаагчдад хамаарах
Хилийн хяналтын, онцгой байдлын байгууллагын ажилтан албан хаагчид /улаан бүс/			
4	1. Амны хаалт 2. Нүүрний хаалт эсвэл нүдний шил	Зорчигч, үйлчлүүлэгчидтэй харьцах ажиллахад	Зорчигч, нэрвэгдэгчидтэй шууд хүрэлцэн ажиллахад

3	1. Нэг удаагийн амны хаалт 2. Бээлий		Халдвартгүйжүүлээгүй тээврийн хэрэгсэл, тээврийн хэрэгслийн бүхээг, ачаа тээш, баримт бичигтэй шууд харьцахгүй ажилтан, албан хаагчдад хамаарах
<b>Хилийн хяналтын, онцгой байдлын байгууллагын ажилтан албан хаагчид /улаан бүс/</b>			
4	1. Амны хаалт 2. Нүүрний хаалт эсвэл нүдний шил 3. Нэг удаагийн ус нэвтрэхгүй халад эсхүл комбинзон 4. Бээлий 5. Нэг удаагийн малгай 6. Углааш	Зорчигч, үйлчлүүлэгчидтэй харьцаж ажиллахад	Зорчигч, нэрвэгдэгчидтэй шууд хүрэлцэн ажиллахад
<b>Халдвартгүйжүүлэлт хийх ажилтан /улаан болон шар бүс/</b>			
5	1. Амны хаалт 2. Нүүрний хаалт эсвэл нүдний шил 3. Нэг удаагийн комбинзон 4. Бээлий 5. Нэг удаагийн малгай 6. Углааш	Халдвартгүйжүүлэлт хийх орчинд ажиллах бусад ажилтан, албан хаагчдад хамаарах	
<b>Цэвэрлэгээ, үйлчилгээний ажилтан</b>			
6	1. Амны хаалт 2. Нүүрний хаалт 3. Бээлий 4. Нэг удаагийн малгай 5. Углааш		Халдвартгүйжүүлэлт хийсний дараа үйл ажиллагаа явуулах

- Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг дархлаажуулалтын бүрэн тунд хамрагдсанаас хойш 14 хоногоос дээш хугацаа өнгөрсөн бол хамгаалах хувцас хэрэгслийн бурдлийг мэргэжлийн байгууллагаас гаргасан зөвлөмжид үндэслэн хэрэглэх.
- Жагсаалтад тусгагдаагүй чиг үүрэг гүйцэтгэх ажилтан, албан хаагчид нь тухайн хилийн боомт, боомтоос гадуурх гаалийн хяналтын бүс дэх мэргэжлийн хяналтын байгууллагын зөвлөмжийг дагна.